

БАТЛАВ
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ПҮРЭВСҮРЭН

2025 оны 05 дугаар сарын 07

ATA14401 9025010818 5890683

“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 05 дугаар сарын 07

Дугаар 06

Налайх дүүрэг

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 13:00 цагт Налайх дүүрэг 3 дугаар хороо, паркийн захиргааны байрны 201 тоот хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/	Асуудал танилцуулах албан тушаалтан	Гарах шийдвэр
1	Байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах тухай	30	Зөвлөлийн дарга	Тэмдэглэл

**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 05 дугаар сарын 07

Дугаар 06

Налайх дүүрэг

Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэргэдэх өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 201 тоот хурлын танхимд 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 13:00 цагт эхэлж 13:30 цагт дуусгав.

Хуралд:

Зөвлөлийн дарга	Н.Пүрэвсүрэн
Нарийн бичгийн дарга	О.Чулуун-Эрдэнэ
Гишүүд	Г.Ганцэцэг
	Б.Түмэнжаргал
	Б.Болортуяа нар оролцов.

Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/21 тоот тушаалын дагуу Байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж авах төсөв батлагдсан. Уг төсвийн хүрээнд тоног төхөөрөмж авах тухай.

СОНССОН НЬ: Байгууллагад шаардлагатай байгаа тоног төхөөрөмжүүдийг тодорхойлж, хурлын өрөөнд тавих индэр, өсгөгч, чадлын оролт зэргийг авах

Н.Пүрэвсүрэн: 2 давхрын 201 тоот хурлын өрөөг тохижуулах шаардлага үүсээд байна. Цаашид байгууллагын болон аж ахуйн нэгжүүдтэй хурал, уулзалт хийх, дүүргийн иргэд болон ахлах ангийн сурагчдын танилцах аялал зэрэг үйл ажиллагаа зохион байгуулагдахад өсгөгч, чадлын оролт, индэр зэрэг зүйлс хэрэгцээтэй байна. Бид хурлын өрөөндөө том дэлгэц авч суурилуулсан боловч хангалттай өндөр дуутай биш байсан. Байгууллагын танилцуулга болон видео сторк зэрэг явуулахад дуу нь сонсогдохгүй байна.

Б.Болортуяа: Батлагдсан төсөвт 1 дүгээр давхрын зүүн зааланд дугуй ширээнүүд авах төсөв хүрэлцэх болов уу? Байгууллагатай танилцахаар ирсэн зочид төлөөлөгчдийг үдэн гаргахдаа халуун цай, уух зүйлс өгөх гэхээр суух ширээ олдохгүй байсан. Хэд хэдэн удаагийн тохиолдлоор би ирсэн зочид тав тухгүй суух газар ч олдохгүй хэцүү байгааг анзаарсан.

Г.Ганцэцэг: Батлагдсан төсөвтөө тааруулаад авахад болохгүй зүйл байхгүй гэж бодож байна. Өөр ямар зайлшгүй чухал шаардлагатай зүйлс байгаа вэ?

О.Чулуун-Эрдэнэ: Бидэнд яг одоо нэн шаардлагатай байгаа зүйлсээ тодорхойлъя. Дугуй ширээ 3ш байхад болох байх гэж бодож байна. Мөн миний анзаарснаар хурлын танхимд индэр зайлшгүй байх шаардлагатай. Бид өмнө нь арга хэмжээ зохион байгуулахдаа соёлын ордны индэрийг гуйж авчирч тавьж байсан. Нааш цааш нь зөөх унаа машинаас өгсүүлээд төвөгтэй юм билээ. Өөрсдийн гэсэн индэртэй болмоор байна.

Б.Түмэнжаргал: Тийм шүү, миний анзаарснаар бас уулзалт, зөвлөгөөн, танилцуулга хийхэд эдгээр зүйлс шаардлагатай харагдсан. Өсгөгч, чадлын оролт зэргийг иж бүрнээр нь авчирч суурилуулах нь зүйтэй. Мөн харуулын ширээ, шилэн хаалгатай шкаф авах хэрэгтэй байна. Хурлын өрөөнд сандалнууд авч тавих хэрэгтэй.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Аз мандах ХХК-ийн дэлгүүрээс
 - Дугуй ширээ – 3ш – 1,140,000
 - Харуулын ширээ - 1ш – 750,000
 - Шилэн хаалгатай шкаф – 2ш – 1,300,000

- Индэр – 1ш – 750,000
- Сандал – 30ш – 5,700,000
- Өлгүүр – 2ш – 360,000
- 2. Домогт тайхарын хишиг ХХК-ийн дэлгүүрээс
- Өсгөгч – 4ш – 900,000
- Пульт – 1ш – 1,950,000
- Чадлын оролт – 2ш – 1,550,000

Нийт – 14,400,000 төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авахаар шийдвэрлэв.

- Тус хөрөнгийг хүлээн авч байгууллагын холбогдох дансанд бүртгэн авахыг Нярав Э.Ундармаад үүрэг болгов.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн

Дарга

Нарийн бичгийн дарга



Н.Пүрэвсүрэн /Ахлах мэргэжилтэн/

О.Чулуун-Эрдэнэ /ГХХА хариуцсан мэргэжилтэн/